

## ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ

/2016 оны 1-р сарын 6-наас 2016 оны 2-р сарын 3-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	I/6	I/13	I/20	I/27	II/03
1	Гурил, I зэрэг, кг	1200	1200	1200	1200	1200
2	Хонины мах, кг/ ястай/	4000	4500	4500	4500	5000
3	Үхрийн мах, кг /ястай/	5500	5500	5500	5500	6000
4	Ямааны мах /ястай /	3000	3500	3500	3500	3500
5	Элсэн чихэр, кг	1500	1500	1500	1500	1500
6	Цагаан будаа, кг	2300	2300	2300	2300	2300
7	Шингэн сүү, л	1600	1700	1800	1800	1800
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг-цагаан	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
9	- Бор ноолуур	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1490	1490
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1600	1600
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1710	1710

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2016 оны 1-р сарын 6-наас 2016 оны 2-р сарын 3-ны хооронд мах, сүү, шатахууны үнэ өөрчлөгдөж гурил, элсэн чихэр, цагаан будааны үнэ тогтвортой байв. Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийгээгүй байна.

**Махны үнэ.** Хонь, үхрийн ястай махны үнэ 1-р сарын 6-наас 1-р сарын 27-ныг хүртэл тогтвортой байсан ба 2-р сарын 3-нд өмнөх долоо хоногийн мөн үетэй харьцуулахад хонины ястай мах 11.1 хувиар, үхрийн ястай мах 9.1 хувиар тус тус өсч харгалзан 5500 төгрөг, 6000 төгрөг болов. Ямааны ястай мах 1-р сарын 13-нд өмнөх долоо хоногийн мөн үеэс 16.7 хувиар өсч 3500 төгрөг болсон ба сүүлийн 4 долоо хоногийн турш ханш хадгалагдаж байна.

**Гурил, элсэн чихэр, цагаан будаа.** Гурил, элсэн чихрийн үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа.

**Шингэн сүү.** Шингэн сүүний үнэ сүүлийн 3 долоо хоногийн турш 1800 төгрөгийн үнэтэй байна.

**Шатахуун.** 2014 оны 1-р сарын 29-нөөс 2016 оны 1-р сарын 20-ны өдрийг хүртэл тогтвортой байсан шатахууны үнэ 1-р сарын 27-ны мэдээгээр өөрчлөгдөв. А-80 бензиний үнэ 5.1 хувь буюу 80 төгрөгөөр, А-92 бензиний үнэ 5.3 хувь буюу 90 төгрөгөөр, дизелийн түлшний үнэ 4.5 хувь буюу 80 төгрөгөөр тус тус буурч А-80 бензин 1490 төгрөг, А-92 бензин 1600 төгрөг, дизелийн түлш 1710 төгрөгийн үнэтэй болов.

